



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/31

Чингис хот

Нууцын тооллого явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 213 дугаар зарлиг, "Зэвсэгт хүчний хэмжээнд дагаж мөрдөх нууц хадгалалт хамгаалалтын заавар"-ын 2.14 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны бэлэн байдлын онц чухал нууц, нууц баримт бичиг, ном материалын 2018 оны хагас жилийн тооллого, шалгалтыг 2018 оны 06 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд явуулсугай.

2. Тооллогын комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Тооллогын комиссын

дарга: Л.Бат-Октябрь -Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд: Э.Бат-Арслан -Цэргийн штабын ОНХСЭрхэлсэн офицер ахмад

Ц.Анумарал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын бичээч

3. Цэргийн штабын дайчилгааны бэлэн байдлын онц чухал нууц, маш нууц, нууц баримт бичиг, ном материалын 2018 оны хагас жилийн тооллогыг заасан хугацаанд чанартай явуулж, материалыг Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газарт хүргүүлж, 2018 оны 06 дугаар сарын 15-нд илтгэхийг тооллогын комисс /Л.Бат-Октябрь/-т даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР